

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Машбат	Дугаар	L217
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Батцэнгэл
Төрсөн газар	Батцэнгэл сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тарвачамбулин хийдийн даа лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тарвачамбуулин хийд	Сүм хийдийн дугаар	АРБЦ 071
Одоогийн сүм хийд	Тарвачамбулин хийд	Сүм хийдийн дугаар	АРБЦ 018
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Архангай аймгийн Батцэнгэл сумын Таравчамбуулин хийд

Д.Мөнхбат: Тэгэхээр Архангай аймгийн Батцэнгэл сумын төвд одоогоос 170- 180 жилийн өмнө байгуулагдсан Сайнноён хан аймгийн хурал номын томоохон газруудын нэг болох Луу гүний хүрээ буюу Таравчамбуулин хийдийн тухай дараах сурвалжлага, ярилцлагыг авч байна. Энэхүү хүрээ анх 1846 онд байгуулагдсанаас хойш 100 шахам жил оршин тогноод 1937, 1398 оны үед хаагдсан хамгийн сүүлд энэ хүрээнд шавилан сууж байсан хүн бол одоогийн Таравчамбуулин хийдийн ловон лам 89 настай Жаамаа гуай ажээ. Гэвч өнөөдрийн байдлаар Жаамаа гуайн биеийн байдал тааруу, хэвтэрт ярилцлага өгөх боломжгүй байсан тул бид Жаамаа гуайн шавь тус хийдийн даа лам Машбатаас багшийнх нь хэлж бичүүлснээр уг хүрээний үүх түүхийг сонирхон энэхүү ярилцлагыг хийсэн болно.

Машбат лам таньд дараах хэд хэдэн асуултыг тавья. Эхлээд хоёулаа нэрнээс нь эхлэе. Луу гүний хүрээ ч гэх юм, Таравчамбуулин хийд ч гэх юм энэ ямар учиртай юм бэ ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Машбат: ЭХлээд энэ хошууг таслахдаа Туслагч гүний хошуу гэж нэртэй байж. Дараа нь Лувсанхайдав гэж ноён хошуу ноён болж тэгээд Богдоос Лувсанхайдав ноёнд гүн цол шагнаснаар Луу гүний хошуу хэмээн алдаршсан. Тэгээд манай хүрээг Луу гүний хүрээ гэх болжээ.

Д.Мөнхбат: Тэгэхээр энэ хүрээ анх Лувсанхайдав ноёны үед байгуулагдсан болохоор Луу гүний хүрээ гэж нэрлэгдэж гэж ойлгож болох үү ?

Машбат: Тийм. Тэгж ойлгож болно. Лувсанхайдав ноёноос өмнө гурван хошуу ноён байсан юм гэнэ лээ. Хамгийн сүүлчийн хошуу ноёноор 5 настай Ширзагд гэдэг хүү үе залгамжилж тэгээд л ардын засагтай золгосон юм гэдэг.

Д.Мөнхбат: Таравчамбуулин гэдэг нь ямар утгатай юм бэ ?

Машбат: Заяын гэгээн Луу гүний хошуугаар дайрч өнгөрөхдөө олбог Таравчамбо судар хоёроо гээсэн юм гэнэ лээ. Тэгээд хийдээ барихдаа анхны авга дуганыг олбог унагасан газар нь шавыг нь тавьж босгон хийдийн нэрийг Таравчамбо гэдэг судрын нэрээс үүдэн Таравчамбуулин гэж нэрлэсэн түүхтэй юм гэнэ лээ.

Д.Мөнхбат: За ингээд Тамирын голын хойт эрэг дээр хожмын Батцэнгэл сумын төвийн энэ газар хүрээний шав анх тавигджээ. Яг хүрээний шав тависан нь хэдэн оны үед юм бол , багш чинь юу гэж айлдаж байх юм бэ ?

Машбат: Үгүй би анх яг шавыг нь 1800-аад оны эхээр л тавьсан болов уу гэж боддог. 1846 он бол хийдийг яг бүтнээр нь барьж дуусгасан он. Чулуу, тоосго нийлсэн 8, модон 2 нийт 10 дуган, 8 дацан 10 жасаатай 510 гаруй ламтай үйл ажиллагаа явуулж байсан гэдэг.

Д.Мөнхбат: За хүрээ хийд үүссэн түүх ийм юм байна. Энэ хийдийн гол шүтээн сахиус нь юу байсан юм бол ?

Машбат: Гол шүтээн нь Дамдинянсан , ядам. Гол сахиус нь Лхам.

Д.Мөнхбат: Лхам сахиус чинь Сайнноён хан аймгийн аймаг хошуудын сахиус байсан үү?

Машбат: Тийм. Сайнноён хан аймгийн хэмжээний сахиус байсан юм гэнэ лээ.

Д.Мөнхбат: Луу гүний хүрээ буюу Таравчамбуулин хийдийн хамгийн анхны тэр 1800-аад оны эхээр өбосгосон авга дацан одоо энэ та нарын сууж хурал хурж байгаа энэ дацан мөн гэсэн үү ?

Машбат: Тийм яг мөн анхны авга дацан.

Д.Мөнхбат: Хийдийн анхны хамба ямар хүн байсан тухай тэмдэглэгдэж үлдээгүй гэж түрүүн багш тань ч та ч өөрөө хэлж байсан харин 1937, 1398 оны үеийн өмнө сүүлчийн хамба нь ямар хүн байсан юм бэ унзад гэсгүй нь ч ямар хүмүүс байсан юм бэ ер нь ямар ямар лам хувраг хүмүүс сууж байсан юм бэ ?

Машбат: Одоо тэр хамгийн сүүлчийн томчуулаас энэ хийдийн шунлайв Ширээт лам хамба өндөр Хансар гэж хүн байсан, унзад нь Мэндбаяр, Гөлөгбаатар гэж чойжин буудаг сүүлдээ Богдын 8 чойжингийн нэг болсон. Энэ хийдийн Норов гэлэнхай гэдэг хүний шавь байсан юм гэнэ лээ Мэндээ унзад гэж. Зая гэгээн хамгийн сүүлд Богдод мандал өргөхөөр явахдаа Лувсанхайдав ноён, Мэндбаяр унзад хоёрыг дагуулан авч явж байсан гэдэг ийм түүх байдаг.

Д.Мөнхбат: Халхад байсан хүрээ хийд, хурал номын газрууд хурал номын өөрийн гэсэн ая дан, дэг жаягтай байж. Танай хийдийн хувьд ямархуу ая дан өнгө төрхтэй байсан юм бэ ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Машбат: Манайх төвдийн Дашлхүмбэ хийдийн ая дан дэгтэй .Зая гэгээн өөрөө дэглэж тавьсан юм гэнэ лээ. Хотод өөр аль ч хийдийн хуралд манайх шиг ая дан их цөөхөн байдаг. Хөгшчүүл яг хуучин тэр уламжлалаараа л бид нарт зааж сургасан одоо тэр хэвээрээ л байгаа.

Д.Мөнхбат: Зая гэгээн төвдийн Дашлхүмбэ хийдийн ая данг хуулбарлаж манай хийдэд тавьсан гэж ярилаа. Заяын гэгээнд төвдөөс тэр хийдийн дэг ая данг хулбарлан энд авч ирэх ямар шалтгаан шаардлага байсан юм бол ?

Машбат: Зая гэгээн Лувсанпэрэнлэй гэгээний эцэг нь Лувсанхайдав ноён юм гэнэлээ. Энэ ийм учиртай Зая гэгээний ээж нь ганц бие зарц эмэгтэй манай энэ хошуунд суудаг байж. Гэтэл нэг шөнө гэр нь шатах шиг болж гэрэл туяа гарч Зая гэгээн төрсөн гэдэг. Ингээд 7 настайд нь Зая гэгээнийг авга дацанд залах ёслол болж нутгийн хүмүүс ноёд лам нар цуглан найр болжээ. Тэнд хонины ууц тавьж тэгээд нэг том лам хонины чанасан толгойг авч Зая гэгээнд өгөн энийг эцэгтээ аваачиж өг гэхэд Зая гэгээн олон хүмүүсийн араар сууж байсан Лувсанхайдав ноёнд аваачиж өгсөн юм гэнэ лээ. Мэндээ унзад бас өөрийнх нь гарын унзад ойрынх нь хүн байсан юм гэнэ лээ тэгээд л түүгээрээ дамжуулан энэ ая данг авчирч тавьсан юм гэнэ лээ.

Д.Мөнхбат: Та түрүүн ярьж байсан нэг зүйл юу гэхээр энэ Луу гүний хүрээний цогчин дуган их том байсан юм гэнэ лээ хэдэн үхэр тэрэг ч гэлээ чөлөөтэй орж нарж багтдаг байсан гэж энэ тухайгаа тодруулаач ?

Машбат: Цогчин дуган. Одоо энэ асрын өмнө туурь нь байгаа 21 ноостой хасаг тэрэг орсон байхад юм орсон шинжгүй байдаг байсан гэж манай энэ гавьж багш бидэнд ярьдаг байсан юм. 2 хаалгатай байсан юм тэгээд баруун талын хаалгаар нь 21 ноостой хасаг тэрэг орсон байхад ер юм орсон шинжгүй байдаг байсан гэж ярьдаг хувьсгалын үед шдээ тэр чинь.

Д.Мөнхбат: Одоо энэ зүүн өмнө талд 11 жилийн сургуулийн агуулах байсан тэр мяндагтнуудын суудаг асар байсан гэж байгаа тиймээ ? Тэр асрын өмнө цамын талбай байсан гэдэг тэгэхээр энэ хийд шашны ямар ямар зан үйл хийдэг байсан юм болоо? Жишээ нь цам гарах, майдар эргэх гэх мэт.?

Машбат: Хаврын дунд сард майдар эргэдэг байсан юм гэнэ лээ. Намрын дунд сард сор залдаг сор залахын өмнө цам гардаг байж надад наян хэдтэй нэг өвгөн ярьдаг байсан юм намар энэ Ганжуурын гэрийн өмнүүр явахаар орой үдэш цамын бэлтгэл хийж байгаа гэж бүрээ бишгүүр хангинаад л сүртэй юм болдог байсан гэж ярьдаг байсан.

Д.Мөнхбат: За ингээд хүрээ хийдэд урьд шавилж сууж байсан лам хуваргууд өндөр насалж хорвоогийн жамаар их л цөөрч дээ. Одоо энэ хавьд л гэхэд ганцхан танай багш Жаамаа гуай л үлдэж та Улаанбаатар хотод манай хийдийн амьд түүх болсон нэг хүн бий гэсэн энэ тухайгаа тодруулаач ?

Машбат: Гандангийн Идгаачойнзонлин дацангийн шунлайв Жагварлын Доржжанцан гэж 90 хүрч яваа өвгөн бий. Одоо бие нь тааруу зайлуул гэртээ хэвтэрт байгаа. 1995 оноос манай хийдийн ерөнхийдээ анхны хамба нь Галсанпунцаг гуай дараачийнх нь Чойдорж гуай, тэгээд энэ Доржжанцан гуай байсан юм. 1990 онд анх нээгдэхэд нь ловон ламаар ажиллаж байгаад 1995 оноос хамба болсон юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Та түрүүн 1990 оноос хойш шинээр байгуулагдснаас хойш тэмдэглэгдэх хийдэд болсон чухал үйл явдлуудын нэгэнд 2000 онд гавьжийн дамжаа барьсан нэг лам бий гэж ярьж байсан тэр хүн мөн үү ?

Машбат: Мөн мөн 2000 онд ганданд гавьжийн дамжаа барьсан юм Чойжамц гуай энэ тэр хамт барьсан байх эндээс бид нар явж би үйлчилж байсан юм

Д.Мөнхбат: За баярлалаа.Таны өгсөн мэдээлэл Монголын сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.200-аад жилийн түүхтэй Сайнноён хан аймгийн буддын шашны томоохон хүрээ хийдийн нэг болох алдарт Луу гүний хүрээний үүх түүх ая дан дэг жаягийг сэргээх буянтай үйлд зүтгэж яваа таны ажил үйлс бүтэмжтэй байх болтугай.

Машбат: баярлалаа.

Д.Мөнхбат: За ингээд Архангай аймгийн Батцэнгэл сумын төв дээрх судалгааны ажлаа дуусгаж байнаа. Энэхүү Луу гүний хүрээнээс үлдсэн буурь , тууриас харахад 1937,38 оны үед сүм хийдийн эсрэг авч явуулсан тухайн үеийн төр нийгмийн хэлмэгдүүлэлтэнд бусад сүм хийдийг бодоход харьцангуй бага өртсөн бололтой. Жишээ нь энэхүү авгын дацан гэхэд 1800-аад оны эхээр баригдсан энэ хийдийн анхны дацан бөгөөд эдүгээ 2007 оны нүүрийг үзээд байж байна. Барилгын хийц, углуурга, заадас холбоосууд , будаг зос хээ хуар чимэглэл ази дорно дахины орнуудын сүм хийдийн уран барилгын агуулга хэлбэрийг харуулж байна. Мөн ядам дуган, цамын талбайн ар талд байх мяндагтнуудын суудаг асар дээвэр нь бүтнээрээ Ядам дуган гэхэд 4 талын хан нь босоо чигээрээ үлджээ.